**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

**НИЙЛҮҮЛЭГЧ**

МОНОС ТРЕЙД ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЦЭРЭНБАТ

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 231

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монос Трейд ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Эм худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 47,040,000 (Дөчин долоон сая дөчин мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Фавипиравир | 1 | Энэтхэг | ширхэг | 3360 | 14000 | 47,040,000 |
| | **Нийт дүн** | | | | | | **47,040,000** |
| | | | | | | | |

ТӨРИЙН САН МЭРГЭЖИЛТЭН 433

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 47,040,000 (Дөчин долоон сая дөчин мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаар | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Фавипиравир | 1 | 23,520,000 | 23,520,000 |
| | **Нийт дүн** | | | **47,040,000** |
| | | | | |

---

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

| | |
|---|---|
| | хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**АХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

рүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн
оргсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
..............................Г.Цэцэнсанаа

рүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын
лтсийн дарга
..............................Т.Бямбасүрэн

рүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн
оргсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
..............................Т.Мөнхтуул

рүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын
лтсийн мэргэжилтэн
..............................Г.Бат-Эрдэнэ

рүүл мэндийн яамны ахлах нягтлан
одогч
..............................Г.Догсмаа

рүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн
эргэжилтэн
..............................Д.Мөнхцэцэг

*4210 Улаанбаатар хот Сүхбаатар*
*дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр*

*Утас:263695*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Монос Трейд ХХК
Эмзүйч менежер
Б.Баярмаа

*Хаяг: БЗД 18-р хороо, Намъянжугийн гудамж, Монос өөрийн байр*
*Утас: 77777080*

*Харилцах банк: Худалдаа Хөгжлийн Банк*

*Дансны дугаар: 423005076*